



**ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 5119

Улаанбаатар хот

**Мэргэжлийн эрх олгох, сунгах сургалт
зохион байгуулах тухай**

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Захиргаа, ҮЭ-ийн хороотой байгуулсан "2017-2018 оны Хамтын гэрээ"-ний 3.19 дэх заалт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 234 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт "Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн 8.4.19 дэх хэсэг, 2019 оны сургалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн сургалтын байгууллага "МКЛ" ХХК-ийн гүүрэн краны оператор, оосорлогч дохиочны эрх олгох, сунгах сургалтад тус компанийн хавсралтад заасан нэр бүхий 56 ажилтныг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ажлын 1 хоног хамруулсугай.

2. Сургалтад хамрагдах ажилтнуудыг сургах нөхцөлөөр хангах түүнийг зохион байгуулан ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэст даалгасугай.

3. Дээрх сургалтын төлбөр болох 1,487,000 /Нэг сая дөрвөн зуун наян долоон мянга/ төгрөгийг сургалтын зардлаас тооцохыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваадулам/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.2019

360070600